

БАТЛАВ:  
УИАНГААТАР НОТ  
"БИДИСЕК" ХК  
Б.ЛХАГВАДОРЖ  
ТУЗ-ИЙН ДАРГА

2014 оны 08 сарын 20 -ны өдөр

## МӨНГӨ УГААХ БОЛОН ТЕРРОРИЗМЫГ САНХҮҮЖҮҮЛЭХТЭЙ ТЭМЦЭХ ТУХАЙ ЖУРАМ

### Нэг.НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1 Энэхүү журмын зорилго нь "БиДиСЕК" ХК-ийн /цаашид компани гэх/ мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх, мэдээлэхтэй холбогдон гарах харилцааг зохицуулна.

1.2 Энэхүү журам нь "Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль", Санхүүгийн зохицуулах хорооны "Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхээс сэргийлэх, харилцагчийг таньж мэдэх, сэжигтэй болон бэлэн мөнгөний гүйлгээг мэдээлэх журам", "Үнэт цаасны зах зээлийн зохицуулалттай этгээдийн үйл ажиллагааны журам" зэрэг холбогдох хууль, журмуудыг мөрдлөг болгоно.

### Хоёр. Харилцагчийг таньж мэдэх

2.1 Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх, мэдээлэх, харилцагчаа таньж мэдэх шаардлагын үүднээс Компани Санхүүгийн зохицуулах хорооны "Үнэт цаасны зах зээлийн зохицуулалттай этгээдийн үйл ажиллагааны журам" -ын 4.1, 4.3, 16-д заасны дагуу харилцагчийн холбогдох мэдээлэл, баримтыг хадгална. Үүнд:

2.1.1 Харилцагч нь иргэн бол түүний овог, эцэг /эх/ийн нэр, өөрийн нэр, оршин суугаа хаяг, регистрийн дугаар, холбоо барих утасны дугаар, иргэний үнэмлэхийн нотариатаар гэрчлүүлсэн хуулбар;

2.1.2 Харилцагч нь хуулийн этгээд бол түүний нэр, хаяг, улсын бүртгэлийн болон татвар төлөгчийн дугаар, харилцах утасны дугаар, улсын бүртгэлийн

гэрчилгээний нотариатаар гэрчлүүлсэн хуулбар, удирдлагын талаарх дэлгэрэнгүй танилцуулга;

2.2 Санхүүгийн зохицуулах хорооны “Үнэт цаасны зах зээлийн зохицуулалттай этгээдийн үйл ажиллагааны журам” -ын 4.4 –т заасны дагуу нэмэлт нөхцөлтэй гэрээ байгуулсан тохиолдолд харилцагчтай компанийн “Тел-И үйлчилгээний журмын” дагуу гэрээ байгуулж, гэрээний хавсралт болох “Харилцагчаа таних” маягтыг бөглүүлнэ.

2.3 Компани нь шаардлагатай тохиолдлолд харилцагчаас мэдээллийг шинэчлэн авч болно.

**Гурав. Сэжигтэй болон Мөнгөн гүйлгээний мэдээллийг мэдээлэх**

3.1 20 сая төгрөг, түүнээс дээш үнийн дүнтэй бэлэн мөнгөний болон гадаад төлбөр тооцооны гүйлгээний тухай мэдээллийг гүйлгээ хийгдсэнээс хойш ажлын таван өдрийн дотор батлагдсан маягт, журмын дагуу Санхүүгийн мэдээллийн албанд мэдэгдэнэ.

3.2 Компани нь харилцагчийн гүйлгээг мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлж, эсхүл гэмт хэрэг үйлдэж олсон орлого гэж баримтын үндсэн дээр сэжиглэсэн, эсхүл мэдсэн бол утас, факс цахим хэлбэр бичгээр 24 цагийн дотор Санхүүгийн мэдээллийн албанд баталсан маягт журмын дагуу мэдээллэнэ.

3.3. Мэдээлэх үүргийг хэрэгжүүлэх ажилтан нь сэжигтэй гүйлгээний тайлан, мөнгөн гүйлгээний тайланг факс, цахим хэлбэрээр, эсхүл бичгээр Санхүүгийн мэдээллийн албанд түүний баталсан маягт, журмын дагуу хүргүүлнэ.

3.3.1 Цахим хэлбэрээр илгээх бол Санхүүгийн мэдээллийн албанаас гаргасан маягтын дагуу бөглөх, тайланд нэвтрэх нууц үгийг урьдчилан мэдэгдэх;

3.3.2 Бичгээр илгээх бол, гарын үсгээр баталгаажуулж, тэдгээрийн үнэн зөв, бүрэн байдлыг хариуцах;

3.4 Компани нь Мөнгө угаах болон терроризмийг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль, тогтоомжийн дагуу сэжигтэй гүйлгээний тайлан, бэлэн мөнгөний гүйлгээний тайланд дурдсан мэдээллийг хуулийн байгууллагаар шалгуулах шаардлагатай гэж үзвэл, холбогдох хуулийн байгууллагад шилжүүлэх ба Санхүүгийн мэдээллийн албанд нэг хувийг хүргүүлнэ.

3.5 Мэдээлэх үүргийг хэрэгжүүлэх ажилтан нь тодорхой нэг гүйлгээ, харилцагчийн талаар Санхүүгийн мэдээллийн алба болон эрх бүхий байгууллагуудад мэдээлэл өгснийг байгууллагын болон мэргэжлийн нууц задруулсан гэж үзэх үндэслэл болохгүй.

3.6 Компани нь сэжигтэй гүйлгээний тайлан, тэдгээрийн талаарх мэдээллийг өгсөн ажилтны нууцлал, аюулгүй байдлыг хангах арга хэмжээг авч ажиллана.

3.7 Компанийн удирдлага, ажилтан нь сэжигтэй гүйлгээний тайланг Санхүүгийн мэдээллийн албанд хүргүүлсэн талаар харилцагчдад ямар нэг байдлаар мэдэгдэхийг хориглоно.

#### **Дөрөв. Мэдээлэх үүргийг хэрэгжүүлэх ажилтан**

4.1 Мэдээлэх үүргийг хэрэгжүүлэх үйл ажиллагааг компанийн "Back Office" алба хариуцах ба тухайлсан мэргэжилтэнг албаны менежер хариуцан томилно.

4.2 Мэдээлэх үүргийг хэрэгжүүлэх ажилтан нь "Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль" болон энэхүү журмыг мөрдлөг болгон ажиллана.

4.3 Мэдээлэх үүрэгтэй ажилтны ажлын гүйцэтгэлд албаны менежер хяналт тавьж ажиллана.

4.4 Мэдээлэх үүргийг хэрэгжүүлэх ажилтанд дараах үйл ажиллагааг хориглоно:

4.4.1 Хууль тогтоомжийн дагуу мэдээлхээс зөвшөөрснөөс бусад хувь хүн, хуулийн этгээдэд харилцагчийн гүйлгээний талаар мэдээлэх;

4.4.2 Сэжигтэй гүйлгээний тайлан болон мөнгөн гүйлгээний тайланг мэдээлсэн, мэдээлэх гэж байгаа тухай хууль тогтоомжийн дагуу эрх олгогдсон байгууллагын албан ёсоор томилогдсон албан тушаалтнаас өөр хувь хүн, хуулийн этгээдэд мэдээлэх;

4.4.3 Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн дагуу тусгайлан хянах гүйлгээ, дансыг хууль тогтоомжийн дагуу эрх бүхий байгууллагын албан ёсоор томилогдсон албан тушаалтнаас өөр хувь хүн, хуулийн этгээдэд мэдээлэх;

4.4.4 Санхүүгийн мэдээллийн албанаас түдгэлзүүлсэн гүйлгээний тухай хууль тогтоомжийн дагуу эрх олгогдсон байгууллагын албан ёсоор томилогдсон албан тушаалтнаас өөр хувь хүн, хуулийн этгээдэд мэдээлэх;

22

4.4.5 Мэдээлэх үүрэгтэй ажилтан болон албаны менежер нь албан үүргийнхээ дагуу олж авсан харилцагчийн гүйлгээтэй холбогдох мэдээллийн нууцлалыг хуульд зааснаас бусад тохиолдолд бүрэн эрхийнхээ хугацаанд болон ажлаас чөлөөлөгдсөнөөс хойш задруулахыг хориглоно.

#### **Тав. Мэдээллийн хадгалалт**

5.1 Компани нь харилцагчийн хийсэн гүйлгээ, данс болон харилцагчийн талаар олж авсан мэдээлэл, баримт бичгийг тухайн данс хаагдсан, эсхүл гүйлгээ хийгдсэнээс хойш таваас доошгүй жилийн хугацаанд хадгална.